

АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ

Монгол улс, Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө,
4 дүгээр хороо, Тэнүүн апартмент 3-205 тоот
Утас: 70133743, 99995143, Факс: (976) 7013-3743
E-mail: acc.fin.audit@gmail.com
accuratefinance_audit@yahoo.com

2021.02.10 № A-12
таний -ны № -т

Аудит, нягтлан бодох бүртгэл,
санхүүгийн зөвлөгөөний
итгэмжлэгдсэн байгууллага

"МОНГОЛ БАЗАЛЬТ" ХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид “Монголбазалт” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон бусад тайлангуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Монголбазалт” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь бүхий л материалаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудиторын үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх, түүвэр шалгалтын арга ашиглан магадлах ажил багтана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Санхүүгийн тайланда нөлөө үзүүлэхүйц материаллаг алдаа илрээгүй.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв толилуулах нь Удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагатай байна.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэнд баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан эсвэл алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

XXX

ЗАХИРАЛ



Ж.ОЮУНБИЛЭГ

УЛААНБААТАР ХОТ
ТТС5684 дт. 5505259



Хуудас № .1 .